

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх, нөөц тогтоогдсон хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл авах (3 багц) зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших XV-020521, XV-020580 тоот алтын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайнууд, Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших XV-021662 тоот хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд геологи хайгуулын ажил гүйцэтгэх, ГХА-ын ажлын үр дүнгээр нөөцийн тайлан боловсруулж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хамгаалах, нөөц тогтоогдсон хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл авах зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨҮГ-ын харъяа “Шижир алт” АҮ-ийн алтын нөөцийг нэмэгдүүлэх, Бор-Өндөр УБҮ-ийн жоншны нөөцийг нэмэгдүүлж үйлдвэрийн бүтээмжийг өсгөх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхийн мэдээлэл /сүүлийн 2 жилийн буюу 2019, 2020 оны санхүүгийн тайлан ирүүлэх/,
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ.
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
 - Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсхүл гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 11 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.
5. Тендерийг 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 11.20 цагт цахимаар нээнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.

22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 504 тоот,

И-мейл: mailbox@monros.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-158